

НЭГДЭЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЕИЙН ЯЗГУУРЫН БА УЛАМЖЛАЛТ СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ АСУУДАЛД

*Б. Наранбаатар
Магистр*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

philosophy@must.edu.mn

Хураангуй: 1-р хэсэгт. нийгмийн давхраажил, анги бүлэг үүсэх хүчин зүйлсэд эрх мэдэл, үүрэг байж нийтлэг нөөц буюу нийгмийн институтын үйл ажиллагааны нөөцийг бүрдүүлдэг. Судлаач Ф.Фукуяма АНУ дахь ази цагаачдын нийгэмлэгийн тэргүүлэгч ба шилжин ирэгсдийн эрх мэдэл, байр суурь (статус) -ыг судалж нийтийн санг арвижуулах үүрэг ба тэргүүлэгчийн хуваарилах эрх мэдэл гэсэн үндсэн 2 талт харилцаа нь цаашлаад эрх чөлөө, эрх, гэрээ гэсэн гурвалсан харилцааны эх үүсвэр болсон гэж үзжээ. Үүнтэй холбоотой орчин үед хяналт нь харилцан итгэлцлыг унагааж байгаа юм. Монголчуудын бэлчээрийн мал ахуй байгалийн саад бэрхшээлийг давах, бэлчээрээ хамгаалах хувийн аж ахуйгаас хэтийдсэн зорилттой харилцан туслалцах харилцаа нь гэрээнээс илүү зохицуулах үүрэгтэй юм.

2-р хэсэгт. 20-р зуунд явагдсан бэлчээрийн мал аж ахуй дахь хувийн аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтын хот айлын уламжлал нэгдэлжих хөдөлгөөний бригад, хэсэг суурь гэсэн бүтцэд нөлөөлж малчдын хөдөлмөрийн хуваарь төрөлжин нарийссан. Хүнд техник нэвтрэхийн хирээр бэлчээр ашиглалт сайжирч хагас суурин аж ахуй үүсэн газар тариалан, үйлдвэрлэлийн бусад салбаруудтай харилцан тэтгэн, хорших чиглэлээр хөгжиж ирсэн. гэвч техник нь мал аж ахуйн уламжлалт технологитой төдий л зохицохгүйн улмаас нүүдлийн язгуур соёлын уламжлал гээгдэх, хувийн ба нэгдэл хоршооллын аж ахуйн зааг ялгаа арилж хөдөлмөрийн үнэлгээний бодит утга алдагдсан байна. Нүүдлийн мал аж ахуй нь нийгмийн институтийн үйл ажиллагааны нөөцийг бүрдүүлэх жас, отог, шавь зэрэг хэв маягтай байжээ.

Түлхүүр үгс: эрх мэдэл, үүрэг, нийтлэг нөөц, хөдөлмөрийн технологийн ба нийгмийн хуваарь, хувийн ба хоршооллын хөдөлмөр зохион байгуулалт

УДИРТГАЛ

Тогтвортой хөгжлийн зорилтуудын 13-т уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, 15-т хуурай газрын экосистемийг хамгаалах хэмээн заасан. Монгол орон дэлхийн дунджаас 3 дахин илүү дулаарсан нь хуурай газрын экосистем болох бэлчээрийн доройтлоор илэрч байна. Бэлчээрийн доройтол нь мөн уламжлалт мал ахуй дахь сүргийн бүтэц алдагдах, мал аж ахуйн салбарын бусад салбаруудтай харилцан уялдах, хамсан тэтгэх чадавхи буурсан зэрэг хүний хүчин зүйлээс хамааран улам эрчимжиж байна. Ийнхүү бэлчээрээ нийтээр эзэмшдэг онцлогтой уялдсан мал аж ахуйн зохион байгуулалтын уламжлал, тэдгээрт оролцогч талуудын харилцаа, үнэт зүйлсийн баримжааг тодорхойлж цаашид мал аж ахуйн

байгальд ээлтэй аж ахуйн бүтцийн хэв маягийг тогтоох шаардлагатай байна.

Монголчуудын уламжлалт нүүдлийн мал аж ахуй бүхий нийгмийн бүтцийн үндсэн ангиуд бол талын язгууртан, феодалууд, лам нар нөгөө талд малчин ард, хамжлага болж байсан. Нүүдэллэх арга ажиллагаа бүхий мал аж ахуйн онцлогоос хамаарч дээрх ангиуд:

✓ Эдийн засгийн хувьд эсрэг сонирхолтойн улмаас түрээсийн харилцаатай.

✓ Албадлагын бус, ёс зүйн сэдлээр тодорхойлогддог харилцаатай ч аль алинд нь мөлжлөгийн хэлбэр байна.

Эдгээр хандлага дараахь байдлаар судлаачдын бүтээлд хөндөгдсөн байна. Феодал нар малчин ардыг нутаг хошууны хил хязгаарын дотор хаашаа нүүх, бэлчээр усыг нь заан өгч өвсний гарц сайтай ус ургамал тэгширсэн бэлчээрийг эзэмшдэг (С.Норовсамбуу, 1965). Ерөөс энэхүү аж ахуй нь байгалийн хатуу ширүүн нөхцлийг харилцан туслалцах, хүчээ нэгтгэх замаар л даван туулах боломжтой. Нөгөөтэйгүүр нүүдэлчид эрхээс үүргийг, эрх чөлөөнөөс хариуцлагыг эрхэмлэх тул нийгмийн байр сууриндаа тохирох эрх үүргийг биелүүлэх нь нэр төрийн хэрэг байдаг. (Дашпүрэв., 2017) Түүхийн аль ч үед бэлчээрийг эзэмших, түүний ашиглалтын боломжийг нэмэгдүүлэхийн тулд худаг ус гаргах, зам гаргах ажлыг урамшууллын болон албадлагын олон төрлийн аргаар хэрэгжүүлж байжээ. Өгөдэй хаан худаг ус гаргах замаар бэлчээр ашиглалтыг сайжуулсан хүнд давуу эрх олгож байсан.


Монголын нүүдлийн мал аж ахуй нь өөрийгөө аргацаасан байдлаас хөдөлмөрөө нэгтгэн хамтач аж ахуй болох нь цаг хугацааны асуудал төдийгүй эрин үеийн шаардлага юм.

Нийгмийн бүлэг бүрэлдэхэд язгуурын соёлын үнэт зүйлсийн нөлөө

Нийгмийн хөгжлийн тодорхой шатуудад хүмүүсийн харилцаанд үнэлэмжийн байр суурь онцгой үүрэгтэй. Судлаач Фукуяма АНУ-ын анхан үеийн цагаачид тэгш эрхийн үзэл санаанаас шатлан захирагдах эрх мэдлийн босоо тогтолцоонд захирагдан байсан тухайн үед гэр бүлийн, ураг удмын, нутаг усны, танил талын хүчин зүйлсүүд зохих үүргээ гүйцэтгэжээ. Зэрэг зиндаанаас хамаарсан эрх нь бусдын эрх чөлөөг хязгаарлах, юуны өмнө цагаач шинэ гишүүний санхүүгийн эрх чөлөөг хязгаарлах байдлаар илэрч байлаа. Ийм харилцаанд тулгуурласан бүлгийг тэрээр Ээлжлэн зээлэх нийгэмлэг гэсэн. Нийтийн хуримтлуулсан санг хуваарилах чиг үүргийг төрийн нэрийн өмнөөс хэн нэгэн хийх үед л нэмэгдэл зардал үүсдэг учраас эрх чөлөөг зөрчиж байгаа хэмээн либертари онол үздэг. (Батчулуун, 2012) Харин өнөөгийн ардчилсан нийгэмд зэрэг зиндаанаас хамаарсан хэрэглээний

бүтэц, эрх ямба, хувийн гарал угсаа дээр дурьдсан нийгмийн бүлгийн бүрэлдүүлэх үүргээ алджээ. Хүнээс үүргээ гүйцэтгэхийг шаардах нь тухайн хүний эрхэлж байгаа байр суурь *нийгмийн хүлээлтэд* хэрхэн нийцэж байгааг илэрхийлэх болсон. Социалист үед нийгмийн статустай тохирсон эрх хэмжээ болон үүргийг биелүүлж ядахнаа эрх нь тодорхой учраас түүнийг хянах шаардлагагүй.

Зураг 1. Уламжлалт ба орчин үеийн нийгэмд нийгмийн бүлэг бүрдүүлэгч талуудын хооронд нийтийн сан бүрдүүлэхтэй холбоотой харилцааны ялгаа



Эх сурвалж: Фрэнсис Фукуяма Итгэлцэл: Нийгмийн буян, хөгжин дэвших зам. УБ., 2014.

Мөлжлөгийн гэмээр харилцаа. Гэвч бүх талаар феодалууд малчнаас хамааралтай учраас өмчлөлийн зарим харилцааг шилжүүлсэн байдаг. Тэгэхээр өмчийн эзэн өөрөө бие даан өмчөө захиран зарцуулж байна гэмээргүй. Тэгэхээр эрхийг харилцан хүлээн зөвшөөрдөг буюу эрх чөлөөгөө хязгаарладаг өөрийн сайн дураар. (Ган-Өлзий Ч., 2017) Нийтлэг

нөөцийг бүрдүүлсэн бол энэ эрэмбийн харилцаа нь итгэлцэл¹¹⁰ д үндэслэнэ.

D. Нийтлэг нөөцийн хяналт.

Нийтлэг нөөц нь гишүүдийнхээ эрсдэл болон боломжийг нээх утга агуулгатай. Хязгаарлагдмал байдлаас шалтгаалж малжих нөөц, хуримтлалгүй бол жасын мал өгч маллуулна. Ш.Нацагдорж “Сүм, хамжлага, шавь ард” (УБ., 1972) бүтээлдээ Халх Монгол дахь Хүрээ хийдийн жасын үйл ажиллагаа, жасын мал хариулагч сүрэгчин ба хөлсний малчин (жасын малчин), жас болон тэдний хоорондын харилцааг нэлээд нарийвчлан авч үзсэн байдаг. Сүм хийд нь мал сүргээ бусдад маллуулахаар өгөхийн зэрэгцээ басхүү тусгай хүн хөлслөн авч маллуулдаг ч байлаа. Тийм хөлсний малчдыг “жасын малчин”, “хөлсний хүн” гэх зэргээр нэрлэж байжээ. Хүрээ хийдийн жасаас малыг хариулахаар авагсад ба энэхүү хөлсний малчид нарын хооронд ямар ялгаа байна вэ гэвэл жасын мал хариулагчид бол жасаас мал хариулсны хөлс хэмээн тусгайлан авдаггүй, харин хариулсан малын ашиг шим, үс ноосыг ашиглах, ачлага уналга эдлэх хэрэглэх эрх бүхий бөгөөд ер нь тэд бол их бага алин боловч биеэ даасан аж ахуйтан юм. Гэтэл хөлсний малчид бол их төлөв гар хоосон ядуучууд бөгөөд тэд хүрээ хийдтэй мал хариулах хөлс хүчээ шууд тодорхой хэлэлцэж малыг сүрэгчин нарын адил удаан бус харин богино хугацаагаар хариулахаар авдаг ажээ. (Ж.Урангуа, 2017) Ийнхүү нийгмийн хөдөлмөрийн хуваарийг нарийсгах үүрэгтэй төдийгүй хянаж тийм аж ахуйтанд бас зарим давуу эрх буюу боломжийг олгож байсан. “Сүм хийдийн жасуудын сүрэг хариулагчдаас уул авч хариулсан малын сүү шимээс их бага аль нэгэн хэмжээгээр авдагаас бус өөр нэмэгдэл албан татвар сүрэг хариулагчдаас авдаггүй байсан гэж баттай хэлж болно (Ш.Нацагдорж., 1972).

Тэгэхдээ тэрхүү хяналт буюу хуваарилалтын эрх мэдлээ хэтрүүлж байна гэсэн маргаан ноёдын дунд гарч байв. То вангийн жасын хөрөнгийг хувьдаа шамшигдууллаа, албадан ажиллуулж амь насыг нь эрсдэлд унагалаа гэсэн гомдлыг Аймгийн чуулган дарга хийж байх үеэр зарим ноёд гомдол бүхий бичиг үйлдэн дээд харьялах газарт явуулсан нь түүний эрхлэх жасын аж ахуйг зогсооход хүргэсэн.

Жасын (Ж.Урангуа, 2017) малыг малчдад тавиулж нэг талаасаа албадлагын мэт боловч тэдэнд итгэл хүлээлгэж байгаа нь нийгмийн капитал. Өрнөдөд эдийн засгийн ухаанд рентийг орлогоос нь тооцож

¹¹⁰ Бэлчээр нийтлэг нөөц болохын хувьд ашиглагч талууд харилцан итгэлцэлд суурилна. Хэрэв ийм нөхцөл бүрдэхгүй бол Нийтлэг эзэмшлийн эмгэнэл (*Tragedy of common resource*)-д хүргэнэ хэмээн Гаррит Хардин (*Garrit Harden*) үзжээ.

татварлах замаар нийгмийн шударга бус байдлыг рент¹¹¹ийн үндэстэй мөлжлөг гэдэг. Харин нүүдэлчдийн нийгэмд язгууртнууд өвс бэлчээр сайтай ус ургамал жигдэрсэн нутаг оронд өөртөө харьяалуулж байсан ч өрнийнх шиг биеэ даасан аж ахуй бус албат харьяат ардаасаа хараат байдалтай аж ахуй юм. Ийм харьяат ард эзэн ноёныхоо өр төлбөрийг хуваан барагдуулах¹¹², зарим төрлийн албыг өмнөөс нь гүйцэтгэх явдал байсаар иржээ.

Үндэсний (Ган-Өлзий, 2019) ийнхүү уламжлалт нийгэмд нийтлэг нөөцийг захиран зарцуулах эрхийг язгууртнуудад эдлүүлэх ч албат нар харилцан солилцоо байдлаар эрх чөлөөгөө эдэлнэ. Ф.Фукуяма Америкийн эхэн үеийн цагаачид уламжлалт харилцаа холбоо тогтоох үнэлэмж болох ах дүүс, танил тал, нутаг усны сүлжээнд үндэслэн нийгэмлэг үүсгэснээр уг нийгэмлэгийн гишүүн хуримтлалаа нийтийн санд төвлөрүүлж нийгэмлэгийн ахлагч түүнийг өөрт нь хэрхэн зарцуулахаа мэдэж шийддэг. Үүнийг харилцан итгэлцэл буюу нийгмийн капиталд үндэслэсэн “Ээлжлэн зээлэх нийгэмлэг” (Френсис, 2014) гэжээ.

Нийгмийн хөгжлийн тодорхой нөхцөлд нийтлэгийг бүрэлдүүлэхэд гол хүчин зүйл болж байсан анги давхарга, тэдгээрийн зэрэг зиндаа, эрх ямба уг нийтлэгийн үнэт зүйлээс хэтийдсэн дээд зорилтыг шийдвэрлэхэд саад болж байдаг. “Алесис де Токвилл хувьсгалаас өмнөх Францын нийгэм хавтгайдаа анги давхаргад хуваагдасанаар, ангийн доторхи жижгэрч шаталсан зиндаа нь хүмүүс нийтлэг сонирхолтой байсан ч тэднийг өөр хоорондоо хамтран ажиллахад нь саад болж байсныг өгүүлжээ.” (Френсис, 2014)

“Хэрэв машинт иргэншлийн ид цэцэглэлтийн үед хөдөлмөрийн технологийн хуваарь ажилтан хүний үүргийг хэсэглэн хуваах, *эзэнгүйдүүлэхэд* илэрч, зөвхөн биеийн хөдөлмөрт л төвлөрдөг бөгөөд эзэн, үйлдвэрлэгч хоёрын хооронд “хөндий цүнхэл” бий болох, хөдөлмөрийн *нийгмийн уян хатан бус хуваарь* оршиход нэрмээс болдог байсан бол өнөө үед огт өөр хандлага илрэх болов. Тухайлбал өрөөсгөл ажилтан, эзэн хоёрын хооронд бий болсон энэхүү “хөндий цүнхэл” нь бүхэл бүтэн чанар бүхий шинэ ажилтнаар, бие даасан бүтээлч шинжтэй төрөл бүрийн хөхөдмөрөөр улам бүр мэдэгдэхүйц “дүүрэх” болов. Хөдөлмөрийн технологийн хуваарь нь түүний бодитойгоор оршин буй нийгмийн хуваарийн зааг хязгаар жинхэнэ

¹¹¹ Рикардо рентийн ойлголтыг үржил шим сайтай газар ашиглаж өмчлөгч илүү давуу талтай нөхцөл бүрдүүлж ашиг орлогоо нэмэгдүүлэх учраас өрсөлдөөний тэгш зарчмын үүднээс татвар оногдуулах хувь гэсэн утгаар хэрэглэсэн.

үгүй болох хандлагыг харуулдаг. Хөдөлмөрийн нийгмийн хуваарьт гарсан өөрчлөлт нь технологийн дэвшилтэт өөрчлөлттэй хамт өөрчлөгдөх, түүний шаардлагын хэмжээнд хүртэл гүйцэн төгөлдөржих талаар нэн удаашралтай байдаг. Энэ тухай Р.Дарендорф 1960 -аад онд "сүүлийн зуун жилийн туршид хөдөлмөр ч, капитал ч өөрийн зааг хязгаараасаа элэгдэн нурах үйл явцад ертсөөр ирэв. Марксын үеийн жигдхэн капиталист анги менежерийн хэсэг, энгийн өмчтөн, санхүүгийн капиталистын хэсэг болон хуваагдан салж, зуун жилийн тэртээх бүрэлдэхүүнээрээ нэг төрөл (гомогенный) байсан ажилчин анги мэргэшил мэдлэг, орлого, нэр хүнд, аж амьдралын түвшин зэргээрээ ялгаатай шинэ зааг хязгаар бүхий давхраа бий болж, ингэснээр энэ хоёр анги өөрсдийн зааг хязгаарыг өргөжүүлэн "цагаан захтнууд" болох түшмэдүүд, бас ажилчдын "шинэ дундаж нийгмийн давхраа" бий болсны дүнд бүрэлдэхүүнийг улам нарийн ээдрээтэй болгов. Гэхдээ энэ бүх өөрчлөлт аж үйлдвэрийн газрын эрх мэдлийн бүтцийг үлэмж хувирган өөрчилсөнгүй" гэж үзжээ. Хөдөлмөрийн технологийн болон нийгмийн хуваарьт гарсан ахиц өөрчлөлт хоорондоо үл тохирох явдал өнөөдөр ч мэдэгдэж байгаа бөгөөд гэхдээ эрх мэдлийн одоо оршин буй бүтэц дуртай дургүй ч, үлэмж хоцорч оройтож байлаа ч гэсэн хэлбэрээ өөрчилдөг жамтай." (Г.Сүрэнжав, 2000)

Нийтлэг нөөц, бэлчээрийн хамгаалах, тогтвортой ашиглахад харилцан итгэлцэл хангалтгүй юм. Уламжлалт нийгэмд технологийн онцлогоос хамаарч харилцан хамааралтай тэр хирээр нөөцийг хуваарилах тэгш бус оролцоотой, эрх мэдлийн ялгаатай нийгмийн харилцаа харилцан тохирч байжээ.

1. НЭГДЭЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ НӨХЦӨЛ ДЭХ УЛАМЖЛАЛТ ҮНЭТ ЗҮЙЛС (1959-1990-ээд он)

Судлаачид уламжлалт нүүдлийн хувийн мал аж ахуйн зохион байгуулалт өөрийн ахуйн хэрэгцээгээ аж ахуйгаасаа хангадаг өөрийгөө аргацаасан аж ахуй бөгөөд малчин хүн хөдөлмөрийн нарийн хуваарьгүй, тиймээс олон талт үйл ажиллагаанд оролцдог гэсэн үзэл хандлагыг баримтлах нь түгээмэл. Хүн бүр чадлынхаа хирээр хөдөлмөрлөж хэрэгцээнийхээ хирээр авна гэсэн зарчим өвөрмөц хэлбэрээр хэрэгжсэн. Хувийн мал аж ахуйн хөдөлмөрөөрөө хорших хэлбэр нь хот айл, саахалт айлын зохион байгуулалт боловч бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлж аж ахуйн хувьд байгалийн нөхцлөөс бүрэн чөлөөт байгаагүй. Нэгдэлжих хөдөлгөөн нь мал аж ахуйг бригад, суурь, хэсгээр зохион байгуулсанаар хашаа хороо барьж өвөлжих, малыг нас хүйс, сүү мах, үржлийн гэх мэтээр ялган хөдөлмөрийн хорших хэлбэрийг бий болгосноор байгалийн хүнд хэцүү бэрхшээл саадыг даван туулахад эерэгээр нөлөөлжээ. Төрөөс хөдөлмөрөөр хоршсон 3-4 айл өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр трактор, хүнд техник хэрэгслийг олгож, мөнгө зээллэгийн онцгой давуу эрх олгож

байсан нь нэгдэлжих хөдөлгөөнийг түргэсгэсэн байна. Ийнхүү хагас суурин буюу нэгдэл, бригадын төвүүд байгуулагдсанаар өвөлжөө хаваржаа барих, засварлах материаллаг бааз бэхжиж, малчид овор ихтэй эдлэл, хураасан хөрөнгөө үлдээн алс хол отор нүүдэл хийж малаа таргалуулдаг болсон байна.

Хөдөлмөр өдрийн хөлс олгох замаар нийгмийн тустай хөдөлмөр эрхлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулахын тулд худаг ус гаргах, малчдад эзэмшүүлэх зэрэг арга хэмжээ үр дүнгээ өгсөн.

Өмнө дурьдсанчлан хөдөлмөрийн хуваарьт үндэслэсэн нийгмийн шатлан захирах социаль бүтэц нь хэрэглээ, үйлдвэрлэлийн тогтсон хэлбэржсэн бүтцийг үүсгэдэг нь дараахь сөрөг талуудтай.

- ❖ Үйлдвэрлэгч нь уг тогтвортой бүлэг, ангийн гишүүдэд л хэрэгцээт бараа бүтээгдэхүүнээр хангадаг. Ардын хувьсгалаас өмнө доншуур худалдаачдаас хэт хараат болох хандлагатай болсон байв. Эрх ямба эдлэх дуртай ноёд өөрсдийн хувийн хэрэгцээт зүйлсийг худалдаачдаас зээлэн харьяат албатууддаа хуваан төлүүлэх замаар байр сууриа бэхжүүлэх эрмэлзэх нь олонтаа байв.
- ❖ Нийлүүлэлтийн хомсдол нь тогтсон зэрэг зиндааны хуваарийг алгасч танил тал, ах дүүс, бусад албан бус холбоо харилцаанд тулгуурлах буюу уламжлалт харилцаа холбоондоо найдахад хүргэдэг.

Нэгдэлжих хөдөлгөөний эхний жилүүдэд нэгдлийн гишүүдийн хөдөлмөрийн хөлсийг цай, тамхи, даалин мэт ахуйн хэрэгцээт бараагаар тооцон олгож байсан ч нэгдлийн материаллаг бааз бэхжин ашиг орлого нэмэгдэхийн хирээр мөнгөн тэмдэгтээр сольсон нь томоохон дэвшил байсан. Гэвч төрийн захиргааны ажилтнууд аж ахуйн ажилд дураараа оролцож нэгдлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг шийдэх болсон. “Мал аж ахуйд шинжлэх ухаан, техник, мал эмнэлэг, мал зүйн орчин үеийн ололт нэвтэрч, өвс тэжээл бэлтгэн, хашаа саравч барих болсноор бэлчээрийн малын өртөг хямдтай олон давуу тал бүдгэрсэн, өөрөөр хэлбэл мал аж ахуй эрхлэх нь илүү их зардал, сайтар арчилгаа маллагаа шаардаж эхэлсэн; Нэгдлийн гишүүн-малчид хашаа саравч барих, худаг ус гаргах, хадлан тэжээл базаах, нүүх суух хөсөг унаагаа хүртэл нэгдлээр бэлтгүүлж, хаана нутаглах, хэзээ нүүх суухаа хүртэл дээрээс ямар шийд өгөхийг хүлээж суун, бэлэн үйлчилгээнд дассан нь малчдын бие даасан, идэвхтэй ажиллагааг алдагдуулж, нүүдлийн амьдралын олон үнэт зүйлс мартагдахад хүргэсэн.” (Ж.Болдбаатар, 2017)

Харилцан туслалцах нүүдлийн мал ахуйгаас гарвалтай үнэт зүйл нь техникийн туслалцаатайгаар хөдөлмөрөөрөө хоршин томоохон зорилтуудыг шийдвэрлэх боломжийг өгсөн. Салбар хоорондын харилцан

тэтгэх боломжтой аж ахуйн үүсвэр тавигдан тэжээлийн аж ахуйн машинт станц, малын ариутгал үржлийн аж ахуй зэрэг дээд эрэмбийн зорилтыг шийдвэрлэх болсон.

Гэвч нүүдлийн аж ахуйн технологи байгаа нөхцөлд хүнд техник нь зориулалтаараа ашиглагдах нь бий ч үндсэн үйл ажиллагаанд эрэг шураг болоогүйгээс сэлбэг хэрэгсэл, төхөөрөмжийн ханган нийлүүлэлтийн хувьд төвөөс байнга хамааралтай байдаг учраас албан бус харилцаа холбоо тогтоох нутаг нугын гэсэн уламжлалт харилцаа батжин тогтжээ. (Дашпүрэв., 2017) Дээр дурьдагдсан Мал аж ахуйн машинт станцад хэрэгцээт тоног төхөөрөмж, техникийг үүрэг зориулалтаас нь гажуудуулж нэгдэлч малчдын хувийн ахуйн үйлчилгээний талын хэрэгцээг хангах чиг үүргийг оруулж байсан нь хүний хэрэгцээг төрөөс төвлөн хангах тухайн үеийн нөхцөл байдлыг харж болно.

Хэдийгээр техник хэрэгсэл хангалтай нийлүүлж байсан ч уламжлалт нүүдлийн арга барилаар мал аж ахуйг хөтлөн явуулж байсан учраас тэдгээр хүнд машин механизм техник нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эрэг шураг болсонгүй ашигт ажиллагаа нь буурч байлаа. МАА-н үйлдвэрлэлийн технологийн тал болон хөдөлмөрийн нийгмийн хуваарийн хоорондын зөрчил ч гүнзгийрсэн байлаа. Ажилтан хүнийг ажлыг тохоон томилох нь удирдлагын шалгуураар хийгдэх учраас нийгмийн хөдөлмөрийн хуваарь уян хатан биш юм. Ажилтан хүн ийнхүү үйлдвэрлэлийн багаж хэрэгсэлд хадагдаж хөдөлмөрийн хэрэгсэл хүнийссэн хэлбэрт орж хүний үйлдвэрлэх хүчний хөгжил багаж хэрэгслийн хүрээнд нэмэлт төдий болсон. “Орчин үеийн техникийн эх үндэс нь нийгмийн нарийн эрэмбэт зохион байгуулалт буюу Л.Мемфордын нэрлэсэн “Мегамашин”-ыг хүн нээсэн 5000 жилийн үетэй холбогдоно. ...Мегамашин нь хүний үйл ажиллагаа, хүсэл тэмүүллийг хязгаарлах замаар материал баялгийг асар их арвижуулдаг тул хүмүүнлэг бус шинжтэй.” (Д.Ганболд, 2012)

Өндөр өртөгтэй техник хэрэгсэл үйлдвэрлэлийн технологийн процесст оролцох замаар бүтээмжийг дээшлүүлэх зорилго бүхий МАА-н машинт станц байгуулагдаж байсан ч ахуйн үйлчилгээний эсвэл МАА-н уламжлалт технологийн зорилтыг хангахад хэт нүсэрдэж байлаа. Тиймээс малчид яваандаа идэвх санаачлага сулрах, хэрэглээ болон техник хэрэгслийн хувьд ч өөрөөс нь үл хамаарсан ханган нийлүүлэлтийн тогтолцоо үйлчилж байсан тул албан бус буюу уламжлалт үнэт зүйлсийн харилцаа холбоо сүлжээ оршсоор байв. Зэрэг зиндааны хэвшсэн тогтолцоо, хөдөлмөрийн нийгмийн хуваарь нь технологийн зорилтыг шийдвэрлэх техникийн шинэлэг бүтээл гаргах нөхцөлийг хумьж байдаг. Гэвч тэрхүү тоног төхөөрөмж хэлбэртэй хөрөнгийн хуваарилалт нь

“Үйлдвэрлэлийн хэрэгсэл болж л хэрэглэгдэж байснаас биш хөдөлмөрийн хэрэгсэл болж байсангүй” (Д.Дашпүрэв, 2022)

Ийнхүү хувийн хэрэгцээт зүйл болон уламжлалт мал ахуйн хүрээний зан үйл хүртэл техникийн оролцоотой хийх болсоноор мал аж ахуйн хүрээнд үүсэн хөгжиж ирсэн уламжлалт гар үйлдвэрлэл, урлал мартагдан сарних, зэргээр *үйлдвэрлэлийн үнэлгээт хөдөлмөр ба өөрийн ахуйн хэрэгцээг хангах үйлдвэрлэлийн* зааг ялгаа бүдгэрч малчдын дунд эсвэл бүхий нөөц бололцоогоо төлөвлөгөөт зорилтын дор хувийн хэрэгцээ, сонирхолоо умартах, эсвэл хувийн хэрэгцээ сонирхолоо төлөвлөгөөт зорилт нэрийн дор халхавчлан гүйцэлдүүлэх замаар хангаж байв. Иймд бид дараахь 2 төрлийн хөдөлмөрийг ялган тодорхойлж болно. Үүнд:

1. *Үйлдвэрлэлийн үнэлгээт хөдөлмөр*: хашаа хороо барих, худаг малтах, өвөлжөө бууц засах,
2. *Өөрийн ахуйн хэрэгцээг хангах хөдөлмөр*: нүүдэл хийх, уналга ачилганы морь мал сурган номхруулах.

Ийнхүү бэлчээрийг ашиглах бололцоог нэмэгдүүлэх худаг, хашаа саравч нь нийтлэг нөөц байх шаардлагатайн эрхээр үйлдвэрлэлийн үнэлгээт хөдөлмөр буюу хамтын хөдөлмөр учраас үйлдвэрлэлийн зориулалттай техник нь энэ хүрээндээ л үр ашигтай юм. “Тийм учир төл бойжуулах, мал саах, ноос авах, жинлэх, хашаа хороо цэвэрлэх зэрэг технологийн бүх ажиллагаанууд гараар хийгддэг, харин мал сүргийг тал хээр, нуга бэлд уламжлалт нүүдлийн аргаар л хариулдаг байв.” (Дашпүрэв., 2017)

Экосистемд хөрөнгө оруулах буюу *бэлчээрийг сэргээхээс* гадна мал аж ахуйн үйлдвэрлэлд шаардлагатай нэмэлт болон зэрэгцсэн өөр төрлийн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тусгай аж ахуйн хүн хүч, хөрөнгө хангалтгүй болдог байна.

Харин өөрийн ахуйн хэрэгцээг хангах үйлдвэрлэлд зориулагдах л юм бол үр өгөөж багасч ирдэг. 3-4 өрх нийлсэн нөхцөлд хамтын хөдөлмөрийн хуваарь илүү оновчтой байна. Энд түүхий эд бэлтгэн нийлүүлэх болон өрхийн дотоод хэрэгцээгээ хангах өрхийн үйлдвэрлэл эрхлэх зэрэг доторхи дагнан төрөлжилт нь илүү тодорхой байгааг судлаачид тэмдэглэсэн байна. Сүүлийн үед гэрээт малчин өрх 3 байх нь бизнесийн чиг баримжаатай өрхийн хувьд ашигтай ажиллаж *том оврын техник хэрэгсэл* худалдан авах замаар хөдөлмөр хөнгөвчилж, зардлаа нөхөх боломжтой байна. Харин амьжиргааны зүйлсээ хангах төдийгөөр л хязгаарладаг өрх нь 200 орчим малтай байна.



Хэдийгээр нэгдэлжих хөдөлгөөн нь хөдөлмөрийн хуваарийг нарийсгасан ч үйлдвэрлэлийн үйл явцын тасралтгүй найдвартай ажиллагааг хангах техник хэрэгслийн ханган нийлүүлэлт буюу аж ахуйн ажил нь ахуйн хэрэгцээг хангах талтай хутгалдсан. Ахуйн үйлчилгээ, гэр ахуйн нүүдэл зэрэг ахуйн хэрэгцээг хангах нүүдлийн мал ахуйгаас зайлшгүй урган гардаг хөдөлмөрөөр хангах боломжтой байтал машинт станцад энэхүү чиг үүргийг нэмсэн зэргээс үүдэн үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа буурсан талтай юм.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Бэлчээр нийтлэг нөөц буюу ашиг хүртэгчдэд нээлттэй байдаг. Нийтлэг нөөцийн онцлог нь хөрөнгө оруулалт шаарддаг, хэдий чинээ хөрөнгө оруулж техник, тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулна төдий хирээр үр ашиг нь өсөн нэмэгдэж байдаг. Иймд хувийн хөрөнгө оруулалтаар нийтлэг нөөцийг ашиглах техникийн боломж хязгаар, ашиглалтын зардал болон нөөц ашигласнаас олсон орлого харилцан хамааралтай байх шаардлагатай. Задгай далай, бэлчээр, сансрын орон зай гэх мэт. Хувийн мал бүхий өрхийн аж ахуй нь дангаараа өөрийн хөрөнгөөр бэлчээрт хөрөнгө оруулах буюу ашиглалтыг нь нэмэгдүүлэх боломжгүй. Харилцан туслалцах өгөөмөр хэм хэмжээний үүднээс харилцан нэгэндээ туслалцах нь ах дүүс, нэг нутаг усныхан хооронд байх тогтвортой үнэт зүйл юм. Бэлчээрээ сайжруулах нь усалгаатай газар тариалан хөгжүүлж малын тэжээл тариалах болон өндөр ашиг шимтэй малын үүлдэр угсааг байнга сайжруулах нэгдсэн зохион байгуулалт юм. Нэгдэлжих хөдөлгөөний үед нэгдэл, тариалангийн САА-аас гадуур нэгдэл хоорондын, эсвэл дээрх 2-ын хосолмол байдалтай Машинт станц, Үржлийн төвүүд ажиллаж байсан. Энэ нь дараахь шалтгаантай. Нэгдлийн мэдлийн том оврын машин, төхөөрөмжийг хувийн ахуйн хэрэгцээндээ ашиглах замаар зардал чирэгдэл болж ашгийг бууруулах, эсвэл хөрөнгө шамшигдуулах үзэгдэл хяналт шалгалтаар илэрч байжээ. Иймд аж ахуйн уламжлалт МАА-н болон

эрчимжсэн МАА, Газар тариалангийн салбар аль алинд нь хамааралтай аж ахуйн бүтэц байх нь эдгээр салбар хоорондын уялдаа хангагдаж тухайн салбарын ажлын байр тогтвортой хадгалагдаж хөдөлмөрийн хуваарь дахь нарийн мэргэшил ч хадгалагдана. Зоо-агротехникч гэхэд махны чиглэлээр төрөлжсөн аж ахуй болон тэжээл үйлдвэрлэлийн аж ахуйн харилцан уялдаат салбар хоорондын ажлын байр юм.

ДҮГНЭЛТ

1. Аливаа систем тэсч үлдэхийн тулд орчиндоо дасан зохицох онцгой чадвараа дагнан хөгжүүлсэн байдаг харин орчны нөлөөллийг багасган тогтвортой оршихын тулд олон талт байдлаар дотоод зохион байгуулалтаа өөрчлөн дээд эрэмбийн зорилтыг хангадаг. Мал аж ахуйн салбарын хувийн аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт нь нийлүүлэлтээс хамаарсан буюу түүхий эд бэлтгэлд чиглэсэн хөдөлмөрийн хуваарьтай болдог. Энэ нь ноолуурын үнийн өсөлтөөс үүдэн ямаан сүргийг дагнан өсгөж байгаагаас харагдаж байна.

2. Бэлчээрийн мал аж ахуй дахь хувийн аж ахуйн нөөц боломжоос хэтэрсэн байгаль цаг уурын бэрхшээлийг даван туулах, малын ариутгал халдваргүйжүүлэл, үржил селекцийн ажил хамтын хоршооллын бүтэц зохион байгуулалт оновчтой юм. Энэ нь аж ахуйг хөдөлмөрийнх хуваарийн хувьд олон талтай, салбар дундын чиг үүрэгтэй байхыг шаарддаг. Тэгэхээр нэгдэлжих хөдөлгөөний үед үүссэн нэгдэл дундын, салбар хоорондын аж ахуйн зохион байгуулалтыг сэргээн хөгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Энэхүү аж ахуйн техник нь мал аж ахуйн цомхон, өртөг багатай технологийн явцтай зохицох эсвэл салбар хоорондын нийтлэг нөөцийг ашиглах, хамгаалахад чиглэсэн уян хатан ажиллагаатай байхаар байна. Голын ай сав дагуу аж ахуйгаа эрхэлдэг “Нэг гол усныхан” малчдын хамтын бүлэг үүссэн нь Экосистемийн тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөөлөх нь дамжиггүй.

НОМ ЗҮЙ

- [1]. Батчулуун, Ч. (2012). Нэгэн хичээлд багтсан Либертари үзэл. Улаанбаатар
- [2]. Сүрэнжав, Г. (2000). ШУТХ-ын нөхцөл дэх хөдөлмөрийн нийгэм философийн асуудал. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр
- [3]. Ган-Өлзий Ч. (2017). Шударга ёсны ЭШ онол. Улаанбаатар: Сансудай
- [4]. Ган-Өлзий, Ч. (2019). Тогтвортой хөгжил нийгмийн шударга ёсны философи. Улаанбаатар: Философийн хүрээлэн
- [5]. Ганболд, Д. (2012). Техникийн философи. Магистрын сургалтанд зориулсан гарын авлага. Улаанбаатар: ШУТИС хэвлэх үйлдвэр
- [6]. Ганболд, Д., Наранбаатар, Б. (2012). Орчин үеийн нийгмийн хөгжлийн онцлогт тохируулан ШУТИС-д философийн хичээлийг зааж буй байдал, хичээлийн ач холбогдол,

тулгамдсан асуудлууд. Монгол дахь философийн сургалт судалгааны өнөөгийн байдал, цаашдын зорилт, 75-89

[7]. Дашпүрэв, Д. (2022). Монголын нийгмийн шинэчлэлтийн үе шатууд. Улаанбаатар: Соёмбо принтинг

[8]. Дашпүрэв., Д. (2017). Монгол нийгэм. Улаанбаатар.: "Сэлэнгэ пресс" ХХК

[9]. Болдбаатар., Д. (2017). БНМАУ-д ардын хувийн аж ахуйтныг хоршоолсон нь: бэрхшээл, зөрчил, үр дагавар (1950-1960-аад он). Ж.Урангуа. (2017). Монголын мал аж ахуйн түүхийн судалгааны тойм. ХХ ЗУУНЫ МОНГОЛ: ТҮҮХ, СОЁЛ, ГЕОПОЛИТИК, ГАДААД ХАРИЛЦААНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД. 179-201

[10]. Урангуа. Ж. (2017). Монголын мал аж ахуйн түүхийн судалгааны тойм. ХХ ЗУУНЫ МОНГОЛ: ТҮҮХ, СОЁЛ, ГЕОПОЛИТИК, ГАДААД ХАРИЛЦААНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД., 202-236

[11]. Френсис, Ф. (2014). Итгэлцэл: Нийгмийн буян, хөгжин дэвших зам. . Улаанбаатар: Непко

[12]. ХХ зууны Монгол: түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд. (2017). (хууд. 428). Улаанбаатар: АдМон ПринТ

[13]. Ш.Нацагдорж. (1972). Сум, хамжлага, шавь ард. . Улаанбаатар

[14]. Энхбаатар А., Г. Д. (2008.). Шинжлэх ухааны философи. (SS101, SS801). Гарын авлага. Улаанбаатар.: ШУТИС-ийн хэвлэх үйлдвэр